

Д.БҮРНЭЭ Д.ЭНХТӨР

ཨྲ།།བོད་ཉིང་མངོན་བརྗོད་ཀྱི་བརྗོད་ཡིག

ТӨВӨД МОНГОЛ
ИЛТ ӨГҮҮЛЭХ
НЭРИЙН ТОЛЬ



ННА 92
ДАА 413
Б-867

Хянасан тохиолдуулсан: Н.С.Яхонтова
Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: С.Хонгорзул

Цаасны хэмжээ: В5
Хэвлэлийн хуудас: 46,2хх
Хэвлэсэн тоо: 500ш
Хэвлэлийн газар: “Удам соёл” ХХК

ISBN 978-99978-2-388-5

Номын талаар холбоо барих утас: 94667144

ӨМНӨХ ҮГ

Монгол, төвөд хэлээр уламжлан ирсэн зохист аялгуу, одон зурхай, анагаах ухаан болон эрдэм ухааны бусад аймгийн ном судрыг уншиж ойлгоход илт өгүүлэх нэрийг зайлшгүй мэдэх хэрэгтэй. Энэтхэг, Төвөдийн бага таван ухааны аймагт багтах илт өгүүлэх нэрийг монголчууд зохиол бүтээлдээ өргөн хэрэглэж, толь бичиг зохиож ирсэн баялаг уламжлалтай. Илт өгүүлэх нэрийг санскритаар *abhidana* гэдэг. *Abhi*-илт, тодорхой, *dhana*-нэр өгүүлэл, хоч, цол, өгүүлэхүй зэрэг утгатай. Төвөдөөр *онжод мин* (*mngon brjod ming*), монголоор нуусан нэр, ёгт нэр, ёгт өгүүлэл гэх зэрэг орчуулсан байдаг. Илт өгүүлэх нэр бол аливаа юм үзэгдлийг хэлбэр дүрс, өнгө үзэмж, бүтэц агуулга, мөн чанар зэрэг олон талаас нь ажиглаж өгсөн нэр юм.

Илт өгүүлэх нэрийг ажиглавал хэлзүйн бүтцийн хувьд дан үг болон холбоо үгээс бүтсэн байна. Илт өгүүлэх нэрийн бүрэлдэхүүнд орсон үгс нэгдэн нийлж нэгэн цогц утга илтгэдэг. Тухайлбал *бүхнийг үүсгэгч* гэсэн нэрийг авч үзвэл *бүхнийг*, *үүсгэгч* гэсэн хоёр үг тус тусынхаа утгаар бус харин нэгдэн нийлж *зүрх* гэсэн шинэ утга үүсгэжээ.

Орчин цагийн хэлний шинжлэлд үгийн утгыг бүх талын холбоо хамааралд авч үздэгийг үндэс болгож илт өгүүлэх нэрийг утга зүйн үүднээс дараах байдлаар ангилж болно. Үүнд:

1. Тухайн юм үзэгдэлтэй учир шалтгааны холбоотой нэр байна. Жишээ нь: *ус баригч* гэж үүлийг (үүл бол бороо орох шалтгаан), *утааны үзүүр* гэж галыг (гал бол утаа гарахын шалтгаан) нэрлэжээ.

2. Тухайн юм үзэгдлийн агуулга, мөн чанараас үүдэн нэрлэсэн байна. Тухайлбал *халуун гэрэлт* гэж нарыг, *сэрүүн гэрэлт* гэж сарыг, мэргэн хүнийг *оюун төгөлдөр*, *оюун сайн*, ухаан төгөлдөр, *бүхнийг мэдэгч*, *бүхнийг ухаарах*, хөхөө шувууг *яруу эгшигт* гэх мэт нэрлэсэн байна.

3. Тухайн юм үзэгдлийн гадаад хэлбэр, өнгө үзэмжээс үүдэж нэрлэжээ. Тухайлбал: морин хараацайг *шөвгөн хошуут*, тогорууг *урт хүзүүт* гэх мэт.

4. Үлгэр домгийн үүднээс нэрлэсэн нь цөөнгүй. Жишээ нь: сарыг *туулай баригч*, *гөрөөсний бэлгэт* гэжээ. Бодьсатва туулай өөрийн биеэр өглөг өгөхийг Хурмаст үзээд машид баясан бахдаж тэнгэр нарт үзүүлжээ. Улмаар хүмүүст үзүүлэхийн тулд бодьсатва туулайг саранд байрлуулснаас сарыг *туулайг баригч* гэж нэрлэх болжээ.

5. Энэтхэг, төвөдийн зан заншилтай холбоотой нэр байна. Тухайлбал, далан түрүүний модыг *алахын тэмдэгт цэцэг* гэж нэрийддэг. Энэтхэг оронд эрт цагт далан түрүүний цэцгийг алах хүний хүзүүнд зүүж байжээ.

Холбоо үгээс бүтсэн илт өгүүлэх нэр утга, бүтэц үүргийн хувьд монгол хэлний хэлц үгтэй төстэй. Монгол хэлний хэлц үг ба төвөд хэлний илт өгүүлэх нэрийн адил төстэй болон онцлог шинжийг авч үзье.

Монгол хэлний хэлц үг хэд хэдэн салаа утгатай байж болдог. Жишээ нь: *гар цайлгах* гэдэг хэлц үг дараах утгатай. Үүнд:

1. бусдад юм өгөх
2. хээль хахууль өгөх
3. бэлэг өгөх

Төвөд хэлний илт өгүүлэх нэр мөн салаа утгатай. Тухайлбал *харанхуйг дарагч* гэж нарыг мөн сарыг нэрлэжээ. *Уснаас аврах* гэсэн нэр малгай, газар дэлхий, уулыг нэрлэсэн бол *хоёр хэлт* гэж тоть, могойг тус тус хэлнэ. Ийнхүү хэд хэдэн өөр юм үзэгдлийг тэдгээрийн адил төстэй шинж байдлаар нэг нэрээр нэрлэсэн байна.

Монгол хэлний хэлц үг ойролцоо утгатай байж болдог. Жишээ нь: нас хөгшрөх, өтөлж доройтох гэсэн хэлц үгтэй *эрүү өвдөг нийлэх, хөгшин хонины насгүй болох* гэсэн хэлц үг ойролцоо утгыг үүсгэнэ. Хэлний шинжлэлд нэг ухагдахууныг зааж, тухайн ухагдахууны хүрээнд утгын өнгө аяс буюу дүр дүрслэл, найруулгын ялгаатай үгсийг утга ойролцоо гэдэг. Энэ үүднээс үзвэл илт өгүүлэх нэр нь нэг юм үзэгдлийг олон янзаар нэрлэсний тухайд бас ойролцоо нэрийн шинжтэй. Энэ чанараар нь илт өгүүлэх нэрийг ойролцоо нэр хэмээн томъёолсон байна¹. Тухайлбал, *огторгуйг хязгааргүй, хязгаараас хагацсан, үл хувирах, завсаргүй, биегүй, зайгүй, уснаа үзэгдэх, бүхнээ тодорхой* гэх мэт нэрлэжээ.

Хэлц үгийг гадаад хэлнээ дүйх хэллэгээр оноож орчуулдаг. Илт өгүүлэх нэрийг орчуулах тухайд "Мэргэд гарахын орон" тольд "бас зохист аялгуусын учраа илт өгүүлэх нэрээр үзүүлсэн илжгийг сайн хоолойт хэмээсэн мэтийг ч мөнхүү тэр нэрээр нь орчуулан үйлдмүй за. Өөрийн нэрээр үл орчуулах бөлгөө. Бусцар болвоос зохисгүй болохын тул болой" хэмээн ёгт утгыг хадгалж орчуулахыг дурдсан байдаг.

Илт өгүүлэх нэрийг ном сударт хэрхэн орчуулсаныг авч үзье. Тухайлбал "Хутагт сайн явдалт ерөөлийн хаан" судрын хоёр орчуулгыг харьцуулж үзэхэд нэгэнд нь утгачилж, нөгөөд үгчилж орчуулсан байна.

Dus gsum gshegs pa mi yi seng ge kun bdag gi ma lus de dag thams cad la lus dang ngag yid dang bas phyag byio гэсэн төвөд өгүүлбэрийг орчуулсан нь:

Эхний орчуулгад *гурван цагт залрагч хамаг бурхан багш нар хоцролгүй тэд л бүгдэд нь би бие, хэл сэтгэлээр сүслээд мөргөмүй.*

Удаах орчуулгад *гурван цагт хүний арслан сайвар одсон хоцролгүй тэд эл бүгдэд би бие, хэл, сэтгэлээр бишрэн мөргөмүү* гэжээ.

Mi yi seng ge буюу *хүний арслан* бол бурханы илт өгүүлэх нэр бөгөөд хоёр дахь орчуулгад ёгт утгыг хадгалж орчуулсан бол эхний орчуулгад бурхан хэмээн ерийн нэрээр орчуулжээ.

Төвөд хэлээр "Дозанлүн", монголоор "Үлгэрийн далай" хэмээн алдаршсан судрын дөрвөн зүйл орчуулгад *bcom ldan 'das* хэмээх илт өгүүлэх нэрийг Тойн гүүш, Ширээт гүүш, Цүлтэмлодой нар *ялж төгс нөгчсөн бурхан* гэж ёгт утгыг хадгалж буулгахын сацуу юуны нэр болохыг нь зааж орчуулсан бол, Зая бандид Намхайжамц *ялаад төгс үлсэн* гэж тодотгогч нэргүй хөрвүүлжээ. Эндээс үзвэл зарим орчуулагч уламжлалыг баримталж орчуулсан байхад зарим нь тодотгогч үг нэмж орчуулахаас гадна ерийн нэрээр хөрвүүлсэн байна. Илт өгүүлэх нэрийг ерийн нэрээр орчуулах нь уншигчид

¹ Цэвэг Ригзин илт өгүүлэх ухаан буюу *mngon brjod rig pa*-г the study of synonyms буюу ойролцоо нэрийн судлал гэж нэрлэжээ. Үз: Tsepak Rigzin Tibetan-English dictionary of Buddhist Terminology, New India, pp. 94.

юун тухай өгүүлж буйг амар хялбар ойлгон мэдэхэд тустай боловч нөгөө талаар найруулгын өнгө аяс болон ёгт утгыг орхигдуулах учир далд утгыг хадгалж орчуулахын сацуу юуны нэр болохыг нь заан тэмдэглэвэл зүйтэй. Илт өгүүлэх нэр нэг юм үзэгдлийг дотоод мөн чанар, гадаад өнгө үзэмж, хэлбэр дүрс тэргүүтнээс үүдэж нэрлэсэн байх бөгөөд тухайн эхэд аль нэрийг сонгож хэрэглэх нь санамсаргүй тохиолдлын зүйл бус, найруулгын дүрслэлийн ялгаатай байна. Тухайлбал, дээр гарсан жишээнд бурханы хоёр зүйл нэр болох *хүний арслан*, *ялж төгс нөгчсөн* зэрэг нь тухай тухайн эхэд бурханы аль нэг онцлог шинжийг тодотгожээ. *Ялж төгс нөгчсөн* хэмээсэн нэр нь дөрвөн шулмыг дарж, сайтар зургаан эрдэм төгсөж сансар нирвааны хоёр хязгаараас нөгчсөн бурханы гол эрдмийг тодотгож байгаа бол *хүний арслан* хэмээсэн нь хүн төрөлхтний эрхэм дээд нь болсон гэсэн утгыг чухалчилж эл нэрийг сонгосон байна. Өөрөөр хэлбэл, илт өгүүлэх нэр найруулгын чухал үүрэгтэй бөгөөд энэ онцлогийг манай зохиолч найрагчид анхаарч байжээ. Тухайлбал, монголын гүн ухаантан Агваанхайдав (1779-1838) "Үг утга тодорхой цадиг" хэмээх төвөд хэлээр шүлгэлсэн зохиолдоо тухайн үеийн нийгмийн амьдралыг хурцаар шүүмжлэхдээ илт өгүүлэх нэрийг чадамгай хэрэглэсэн байдаг.

Хосгүй бурханы шашны амийн эцгийн эрлэгийн эзэн (эрлэг)

Хоёр төрсөн (гэлэн) өлзий болсон (өлзий бус) бас нөхөр (шавийн шавь) тэдгээр

Олиггүй үхээрийн орноос шаналсаар шахагдаж гарсан

Орогч (нимба мод) найлзуур төгс эхэд (янхан эм) шунан зуурсан гахай

Олонхи нь сэтгэлд хэвтсэний (шулам) алба гүйцэтгэх зарц мөн².

Агваанхайдав энэ шүлэгтээ сахил санваараа цалгардуулж "урин тачаангуйн хурц илдийг боловсруулахын эрдмийг судалсан" бусармаг явдалтай лам хувраг нарыг шүүмжилжээ. Энэ зохиолыг нэрт төвөдөч Ч. Алтангэрэл орчуулахдаа илт өгүүлэх нэрийг үгчлэн буулгаж, хойно нь тэдгээрийн ерийн нэрийг бичсэн байна. Энэ нь илт өгүүлэх нэрийг ерийн нэрээр утгачилж орчуулбал тухайн зохиолын шүүмжлэлийн хурц өнгө аяс, зохиолын амт шимт гээгдэхийг анхаарсан хэрэг бололтой. Ер нь энэтхэг, төвөдөөс гаралтай илт өгүүлэх нэрийг монголын буддын утга зохиол төдийгүй монгол сурвалж бичиг туурвигчид ч хэрэглэж иржээ. Тухайлбал: Лувсанданзангийн "Алтан товч"-д Шихи хутаг Чингис хааныг магтан дуулсан нь:

Гүүр үл талбигдах өргөн их Хэрлэн мөрөн минь

Хөлөгт үл давагдах өндөр их хан Дэсэ уул минь

Хөвчин бүгдийг асрагч *алтан умайтын* хөвгүүн минь

Хүмүүний эрхт төрсөн сод богд эзэн минь гэх буюу

Бэсүүдийн Зэв мөн Чингис хааныг магтан

Олон зөгийсээр цогцолсон бал ихт бадам лянхуа минь

Осолдол үгүй шинэд дүүрсэн гэрэл ихт *гүмүдаан садан* минь

хэмээсэн шүлгийн *алтан умайт* бол Эсэр тэнгэрийн нэр, *гүмүдаан садан* бол сарны илт өгүүлэх нэр болно. Шүлэгч Лувсанданзан Чингис хааныг буддын

² Ч.Алтангэрэл, Монгол зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл, 1-р дэвтэр, УБ., 1967, 75-р тал.

шашны Эсэр тэнгэр болон харанхуйг гийгүүлэх шинийн тэргэл сарантай тус тус зүйрлэж магтсан байна.

Илт өгүүлэх нэрийг зохиолын нэр гарчиг, тахил төгсгөлийн шүлэгт ч өргөн хэрэглэж иржээ. Тухайлбал: дундад зууны монгол түүхчдийн зохиол бүтээлдээ олонтоо эш татдаг Тавдугаар Далай ламын бичсэн "Rgyal ba lnga ba'i deb ter" хэмээх түүхэн сурвалж бичгийн нэр нь "Залуусын баяр хурим хаврын хатны дуун эгшиг" нэртэй. *Dryid kyi rgyal mo* буюу *хаврын хатан* бол хөхөө шувууны илт өгүүлэх нэр бөгөөд тиймээс ч эл зохиол "Залуусын баяр хурим хөхөө шувууны дуун эгшиг" хэмээх нэртэй. Зая бандид Лусанпэрэнлэйн зохист аялгуугаар бичсэн нэгэн зохиолыг "Утгын гучин таван чимгийн үлгэр өгүүлэхүй *Эсэрваагийн охиныг* баясгах дуун эгшиг" гэдэг. Эсэрваагийн охин бол яруу найргийн тэнгэр гэгддэг Сарасвати буюу төвөдөөр Янжинлхам, монголоор Эгшигт эхийн нэр болно.

Ийнхүү илт өгүүлэх нэр шүлгийн хэмнэл хэмжээ тааруулах, зохиолын хэл найруулгыг уран тансаг, шим шүлттэй болгох үүрэгтэй.

Илт өгүүлэх нэрийн толийн тухай

Энэтхэг орноос үүсэлтэй илт өгүүлэх нэрийн анхны толь бичигт МЭ-ий VI-VIII зуунд зохиогдсон Амарасимхагийн (тө. *chi med seng ge*) *Амаракоша* (тө. *mngon brjod kyi bstan bcos 'chi ba med ba'i mdzod*, мо. Илт өгүүлэхүйн шастир үхэлгүйн сан) нэрт толийг оруулдаг. Тус толийг төвөд, монгол хэлнээ орчуулжээ. Монгол Данжуурын 205 дугаар ботид тус зохиол орсон байхаас гадна XII зуунд энэтхэгийн эрдэмтэн Хемачандрагийн зохиосон *Абхидханачинтамани* (тө. *mngon brjod kyi bstan bcos sna tshogs gsal ba zhes bya ba ming gzhan du mu tig phreng ba*, мо. Илт өгүүлэхүйн шастир элдэв зүйлийг тодруулагч бус нэр сувд эрих хэмээгдэх) толь 221 дүгээр ботид хэвлэгджээ. Төвөдийн их хэлмэрч Шондондоржжалцан энэтхэгийн ухааны орны гол шастир "Зохист аялгууны толь" ба "Ороонго мод", "Лус бүгдийг баясгах" тэргүүтэн илт өгүүлэх нэрээр чимсэн олон шастирыг 13-р зууны үед төвөд хэлнээ хөрвүүлэн буулгажээ. Мөн үед Амаракоша толийг Ярлүнба Дагбажалцан Балбын орны Ямвуу балгаст төвөд хэлнээ орчуулж, Гой лозава энэтхэг шастир, орчуулгын хуучин барыг тулгаж, утгыг шинжлэн орчуулгыг амар хялбар үйлдэн бард бүтээжээ. Тэр цагаас эхлэн төвөд мэргэд илт өгүүлэх шастир олныг зохиосон байна. Төвдийн эрдэмтэн дэв Ринбүнба Жигдэнванчүгдагвадорж "Илт өгүүлэхийн шастир мэргэдийн чихний чимэг" (тө. *mngon brjod kyi bstan bcos mkhas pa'i rna rgyan*) хэмээх шастирыг 1521 онд зохиожээ. Тус бүтээл олны дунд их алдаршсан ба 18-р зууны үед Долдугаар далай лам уг шастирт төгсгөлийн үг бичиж модон бараар хэвлэжээ. "Илт өгүүлэхийг мэдвээс нэрд үл мунхрах" учир монголын мэргэд их, бага таван ухаанаар бичсэн судар шастир таа илт өгүүлэх нэрийг өргөн хэрэглэж, зохиол бүтээлдээ оруулжээ. Тухайлбал монголын эрдэмтэн Сүмбэ хамба Ишбалжир (1704-1788) "Зохист аялгууны толиос номлосон чимгүүдийн үлгэр өгүүлэхүй одны үзэсгэлэнт эрих хийгээд илт өгүүлэхүйн цөөн хураангуй сэлт" (*snap ngag me long las bshad pa'i rgyan mams kyi dper brjod nyung 'dus bcas*) гэдэг номынхоо төгсгөлд зохист аялгуунд гардаг зарим илт өгүүлэх нэрийг хавсаргажээ. Агын дацангийн ширээт лам Төгөлдөрийн Галсанжамба "Сарны

гэрэл" (*mngon brjod kyi ming mams ka 'phreng du bsgrigs pa blo gsar ku nda bzhad pa'i zla zer zhes bya ba bzhugs so*) хэмээх илт өгүүлэх нэрийн толийг XIX зуунд зохиосноос³ гадна төвөд-монгол толь бичгүүдэд ч илт өгүүлэх нэрийг оруулжээ. Мөн монгол хэлээр монгол бичгээр зохиосон илт өгүүлэх нэрийн толь болох "Чихний чимэг"⁴, тод үсгээр бичсэн илт өгүүлэх нэрийн толь бичиг⁵ байдгийг гадаад дотоодын эрдэмтэд судалгааны эргэлтэд оруулаад байгааг дурдах хэрэгтэй.

"Илт өгүүлэх нэрс нь энэтхэг төвөдөөс монголд дэлгэрсэн нь үнэн боловч монголын утга зохиолд урнаар өгүүлэхийн олон арга хэрэглүүр байсаар ирснийг тэмдэглэх нь зүйтэй. Учир нь илт өгүүлэх нэр лүгээ төсөөтэй монгол үг хэллэг байдаг нь илт өгүүлэх нэр анх мөн тийм л хэлбэрээр үүссэн байж магадгүй гэсэн таамаглалыг төрүүлж байгаа юм. Ялангуяа илт өгүүлэх нэрсийн дотор шүтлэг, цээрлэлийн холбогдолтой нэр цөөнгүй байгаа нь үүнийг батлах нэг баримт гэж үзвэл зохино. Монголчууд нэгэн зүйл жимсийг *үхрийн нүд*, үнэгийг *аргат шар*, *зальт шар*, чоныг *хээрийн боохой*, *анадаг саарал*, арсланг *араатны хаан* гэдэг. Тэрчлэн өлгийтэй хүүхдийн хүйсийг мэдэхгүй хүн "буга намнагч уу, булга зүйгээч үү", "уурга чирэх хүн үү, бортого чирэх хүн үү" гэж асуудаг байсан ба хүүхдийн эцэг эх хариуд нь хүү бол "буга намнагч", охин бол "булга зүйгээч" гэж хэлдэг байжээ"⁶.

Монголын буддын утга зохиол, энэтхэг, төвөд, монголын уран зохиолын харилцаа холбоог судлахад тустайг бодож илт өгүүлэх нэрийн толийг анх 2003 онд хэвлэн нийтлүүлсэн билээ. Эдүгээ тус толь ховордсон тул өмнөх хэвлэлийг хянан засварлаж, бас шинэ үг хэллэгээр баяжуулж хоёр дахь хэвлэлийг бэлтгэлээ. Энэхүү толийг бэлтгэхдээ төвөдийн эрдэмтэн Ринбунба Жигдэнванчүгдагвадоржийн "Мэргэдийн чихний чимэг" толийг үндэс болгож, илт өгүүлэх нэрийн бусад толь, судалгааг ашигласан болно.

Юм үзэгдлийг ёгтолж нэрлэх нь энэтхэг, төвөдийн ард түмний ертөнцийг үзэх үзэл, хэл, ёс заншил, шүтлэг бишрэлийн талаар тодорхой ойлголтыг бидэнд өгч, эдгээр ард түмэнтэй шашин соёлын нэгэн шижмээр холбогдсон манай ард түмний ёс заншлыг судлахад ч сонин баримт болох учир бид эл толийнхоо төгсгөлд илт өгүүлэх нэрийн тайлбараас орчуулж хавсаргав. "Мэргэд гарахын орон" толь бичгээс гариг эрхэсийн холбоотой илт өгүүлэх нэрийг бусад толь бичгээр нэмэн дэлгэрүүлж бас хавсаргав. Тайлбарыг ашиглахад амар хялбарыг бодож монгол нэрийн хэлхээс хийв.

³ Н.С.Яхонтова, *Один из источников поэтических выражений (тиб. mngon brjod) в словаре Суматиратны* // Монгольский сборник Тексты и контексты. Российский государственный гуманитарный университет, Москва, 2015, стр.55-76

⁴ *Īkin-ü ċimeg* (эх бичгийн судалгаа), удиртгал бичиж, галиг, тайлбар, үгийн хэлхээ үйлдсэн Ц.Батдорж, эрхлэн нийтлүүлсэн Ш.Чоймаа, Улаанбаатар, 2009.

⁵ *Ойратский словарь поэтических выражений*, факсимиле рукописи, транслитерация, введение, перевод с ойратского, словарь с комментариями, приложения Н.С.Яхонтовой, Памятники письменности Востока СХХ, Издательская фирма "Восточная литература", Москва, 2010

⁶ О.Сүхбаатар, *Илт өгүүлэх нэрийн асуудал* // Монгол хэлний үгийн сан, нэр зүйн судалгаа, ред.О.Самбуудорж, УБ., 43-р тал.

Ингэхдээ төвөд нэрийг бас бичихийн хамт зарим түгээмэл хэрэглэгддэг тэнгэрийн нэрийн санскрит нэрийг бас бичсэн болно.

Тус тольд илт өгүүлэх нэрээс гадна зарим төрөл утгатай үг, ижил нэр, нэрийн зүйл (*ming gi rnam grangs*) орсон нь төвөд-монгол хэлний үгийн сангийн судлалын чухал хэрэглэгдэхүүн болох юм.

Эндүү ташаа зүйл байх аваас хүлцэл өчихийн хамт доорх хаягаар саналаа ирүүлэхийг хичээнгүйлэн хүснэм.

Улаанбаатар-13 шуудангийн хайрцаг 90. Харилцах утас 94667144.

Ном зүй

1. Ч.Алтангэрэл, Монгол зохиолчдын төвдөөр бичсэн бүтээл, 1-р дэвтэр, УБ., 1967.
2. Бүрнээ Д, Энхтөр Д, Төвөд-Монгол толь, Улаанбаатар, 2017.
3. Бүрнээ Д, Энхтөр Д, Төвөд-Монгол илт өгүүлэх нэрийн толь, Улаанбаатар, 2003
4. Бүрнээ Д, Илт өгүүлэх нэрийн учир. МУИС, МСС-ийн ЭШБ, 10 (122), Улаанбаатар, 1997, 126-130-р тал.
5. Бүрнээ Д, Бурхан багшийн илт өгүүлэх нэрийн учир. Буддын судлал, Улаанбаатар, 1998, 95-105-р тал.
6. Бүрнээ Д, Майдар бурханы илт өгүүлэх нэрийн тухай, Майдарын эрин: Нийгмийн хөгжлийн чиг хандлага сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний анхдугаар бага хурлын эмхтгэл, Улаанбаатар, 2013, 185- 191- тал.
7. Норовдадүл, Цэрэннамжил, *Mngon brjod rgya mtso'i thigs kyi rtsa 'grel*, 1982.
8. Ойратский словарь поэтических выражений, факсимиле рукописи, транслитерация, введение, перевод с ойратского, словарь с комментариями, приложения Н.С.Яхонтовой, Памятники письменности Востока СХХ, Издательская фирма "Восточная литература", Москва, 2010
9. Рерих Ю.Н. Тибетско-русский словарь с санскритскими параллелями, Выпуск 1-11. Под общей редакцией Ю.Парфионовича и В.Дылыковой, Москва, 1983-1987.
10. Сумадирадна, *Bod hor gyi brda yig ming tshig don gsum gsal bar byed pa mun sel sgron me*, Vol. I-II. CSM. Ulaanbaatar, 1969.
11. Сүхбаатар О, Монгол хэлний харь үгийн толь, Улаанбаатар, 1997.
12. Сүхбаатар О, Монгол хэлний үгийн сан, нэр зүйн судалгаа, ред.О.Самбуудорж, Улаанбаатар, 2014
13. Цэвэл Я, Монгол хэлний товч тайлбар толь, Улаанбаатар, 1966.
14. Яхонтова, Н.С, *Один из источников поэтических выражений (тиб. mngon brjod) в словаре Суматиратны //Монгольский сборник Тексты и контексты. Российский государственный гуманитарный университет, Москва, 2015.*
15. *Bod rgya tshig mdzod chen mo, Stod cha, Bar cha, Smad cha, Mi rigs dpe skrun khang*, 1985.

16. Bod rgya shan sbyar gyi shes bya'i rnam grangs kun btus tshig mdzod, Mtsho sngon mi rigs par khang, 1987.
17. Chi med sengge, Mngon brjod kyi bstan bcos 'chi ba med pa'i mdzod ces bya ba bzhugs so, Mtsho sngon, 1995.
18. *Čikin-ü čimeg* (эх бичгийн судалгаа), удиртгал бичиж, галиг, тайлбар, үгийн хэлхээ үйлдсэн Ц.Батдорж, эрхлэн нийтлүүлсэн Ш.Чоймаа, Улаанбаатар, 2009.
19. Das S.Ch, Tibetan-English dictionary, Third Reprinting, Compact Edition, Japan, 1977.
20. Galsan, Töbed mongyol emnelge-yin toli, 1982.
21. Merged yarqu-yin oron, Mongyol tulγur bičig-ün čubural, ündüsüten -ü keblel-ün qoriy-a, 1988.
22. Mngon brjod kyi 'grel pa btus bsgrigs legs bshad 'dren pa'i dung sgra, Mi rigs dpe skrun khang, 1993.
23. Mngon brjod kyi bstan bcos mkhas pa'i rna rgyan, Mi rigs dpe skrun khang, 1985.
24. Norjin Z. nar, Mongol kelen-u toli, Öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a, 1999.
25. Rasičeren G, Oyun-i todurayuluyči erdeni erike, (Degedu, dooradu debter) Öbür mongyol-un soyol-un keblel-ün qoriy-a, 1998.
26. Rin spungs Ngag dbang 'jig grags, Mngon brjod kyi bstan bcos mkhas pa'i rna rgyan, Pe cin, 1985.
27. Sečenčoytu, Mongol üges-un ijayur-un toli, Öbur mongyol-un arad-un keblel-ün qoriy-a, 1988.
28. Tsepak Rigzin, Tibetan-English Dictionary of Buddhist Terminology, Library of Tibetan works and archives, 1986.
29. Qorin nigetü tayilburi toli, Öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a, 1979.

Гарчиг

Өмнөх үг	3
Төвөд монгол илт өгүүлэх нэрийн толь	13
Хавсралт нэг	486
Дөрвөн улирлын илт өгүүлэх нэр	486
Төвөдийн арван хоёр сарын илт өгүүлэх нэр	486
Өдөр хоногийн илт өгүүлэх нэр	488
Долоон гаригийн илт өгүүлэх нэр	489
Хорин найман одны илт өгүүлэх нэр	494
Тооны илт өгүүлэх нэр	496
Хавсралт хоёр	499
Илт өгүүлэх нэрийн тайлбар	499
Бурхан, бодьсатвын нэр	499
Тэнгэрийн орон, тэнгэрийн нэр	505
Байгалийн юмс үзэгдлийн нэр	516
Домгийн холбоотой нэр	526
Ургамлын холбоотой нэр	528
Амьтны нэр	534
Жигүүртний нэр	538
Хүн, хүний бие эрхтний нэр	540
Хүний шинж чанар, язгуур угсааны холбоотой нэр	543
Гоёл чимэг, эдийн холбоотой нэр	545
Эрдэнэсийн нэр	545
Цэргийн хэрэглэл, дайн тулалдааны холбоотой нэр	546
Аж байдлын холбоотой нэр	546
Хавсралт гурав	547
Тайлбарын нэрийн хэлхээс	547